



**ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл, шаардлага:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3.10-т “Технологид суурилсан даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, 4.3.3-т “Зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт болон нийлүүлэлтийг дэмжиж, хөрөнгө оруулагчдын төрөл, оролцоог нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний шинж чанараас хамаарсан ялгаатай зах зээлүүдийг хөгжүүлэх”, Засгийн газрын 2019 оны 163 дугаар тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 3.3.5-д “автотээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох замаар төр, иргэнд учрах санхүүгийн дарамтыг бууруулах” гэж тус тус тусгасан байдаг.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтын 45-т Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж “Жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой болгох, Албан журмын даатгагчдын холбооны чиг үүрэг, зохион байгуулалтын тодорхойгүй байдлыг арилгах, даатгуулагч, хохирогч нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргахад хохирол үнэлэгч заавал оролцох шаардлагыг хасаж, холбогдох авто засвар, үйлчилгээ болон эрүүл мэндийн байгууллага оролцох боломжийг бүрдүүлэх, даатгагч, даатгуулагчийн үүргийг тодорхой болгох, даатгалын үнэлгээний хэмжээ, хураамж тооцох аргачлал, итгэлцүүрийг шинэчлэх” зорилтыг дэвшүүлсэн.

Практик үндэслэл, шаардлага:

Монгол Улсад Жолоочийн Даатгалын тухай хууль нь 2011 онд батлагдан 2012 оноос мөрдөгдөж эхэлсэн нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг Монгол Улсад хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бий болгосон.

Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу жолоочийн хариуцлагын даатгалыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа ердийн даатгагч нар (14 компани) хийж байгаа бөгөөд Албан журмын даатгагчдын холбоо нь жолоочийн даатгалын сан, шуурхай алба болон мэдээллийн нэгдсэн санг эрхлэн явуулж байна. Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ 2016 онд 463802 байгуулагдаж, 27.8 тэрбум төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлж байсан бол эдгээр үзүүлэлтүүд өсч, 2020 оны IV улирлын байдлаар 635558 гэрээ байгуулагдаж, 34.6 тэрбум төгрөг (жилд дунджаар 8.9 хувийн өсөлттэй байна) буюу ердийн даатгалын нийт хураамжийн 17.3 хувийг бүрдүүлсэн байна. Түүнчлэн жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөрт 2016 онд 14.8 тэрбум (нийт нөхөн төлбөрийн 43%), 2020 онд 17.5 тэрбум төгрөг (нийт нөхөн төлбөрийн 30%)-ийг олгожээ. Үүнээс үзэхэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал нь даатгалын салбарын хураамжийн орлогын 17.3 хувийг бүрдүүлж, зам тээврийн ослоос үүссэн санхүүгийн хохирлыг багагүй хэмжээгээр нөхөн төлж, Монгол Улсын иргэд, даатгуулагчдад үзүүлэх үр ашгийн нөлөөлөл их байна.

Гэвч Санхүүгийн зохицуулах хороонд даатгалын асуудлаар ирүүлж байгаа өргөдлийн дунджаар 26.4 (2016 онд 36, 2017 онд 32, 2018 онд 16, 2019 онд 23, 2020 онд 25 хувийг тус тус эзэлсэн) хувь нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай холбоотой байгаа нь уг хуулийн дутагдалтай талуудыг илрүүлж, хуулийг өөрчлөх, шинэчлэх, олон улсын сайн туршлагыг авч хэрэгжүүлэх, мөн хуулийн хамрах хүрээ, зохицуулалтыг боловсронгуй болгох, жолоочийн даатгалын үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэд технологи ашиглах эрх зүйн орчинг бүрдүүлэх зэрэг зайлшгүй шаардлагууд үүсч байна.

Жолоочийн даатгалын тухай хуулиар даатгагч, даатгуулагчтай даатгалын гэрээ байгуулж, хуульд заасан нөхцөл, хэмжээгээр хохирогчид нөхөн төлбөр олгох үүрэг хүлээсэн, жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд хэрэгжүүлэх бөгөөд хуульд заасан тодорхой зорилгын хүрээнд хэд хэдэн даатгагч хамтран жолоочийн даатгалын санг байгуулж, сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг Албан журмын даатгагчдын холбоо хариуцан ажиллахаар тусгагдсан байдаг.

Тус хуулийн зорилт нь жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах, зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршдог бөгөөд тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал хамрагдах, хохирогчид нөхөн төлбөр олгох, жолоочийн даатгалд даатгуулаагүй жолооч замын хөдөлгөөнд оролцохгүй байх, зам, тээврийн ослын улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах санхүүгийн эх үүсвэр бий болгох гэсэн үндсэн зарчмуудтай.

Хуулийн дээрх зорилт, зарчмууд нь практикт дараах үл ойлголцол, хүндрэлийг бий болгож байна. Үүнд:

Хуулийн зорилт нь жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах атал зарчим нь тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал хамрагдах гэж заасан нь зам тээврийн ослын улмаас үүдэх эрсдэл, бусдын өмнө хүлээх хариуцлагыг яг аль субъектэд хүлээлгэх үндсэн зорилго нь ойлгомжгүй, улмаар даатгалын хураамж, итгэлцүүр тооцоход хүндрэл үүсгэдэг;

Автотээврийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15-д заасан тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч болон "С", "D" ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч нь тээврийн хэрэгслийн өмчлөгч эсэхээс үл хамааран жолоочийн даатгалд заавал даатгуулна гэж заасан нь практикт "С", "D" тээврийн хэрэгслээр ажил, үйлчилгээ явуулдаг тээврийн хэрэгслийн өмчлөгчийн дийлэнх нь уг тээврийн хэрэгслийг жолоодох эрхтэй мэргэшсэн жолооч биш байдаг тул тухайн тээврийн хэрэгсэлд жолоочийн даатгалын 2 гэрээ байгуулах шаардлага тулгардаг. Олон улсын сайн туршлагыг судлан үзэхэд, замын хөдөлгөөнд оролцож буй жолооч бүр заавал даатгуулах эсвэл авто тээврийн хэрэгслийн өмчлөгч нь даатгуулах зэрэг ялгаатай талууд байдаг. Иймд энэхүү жишиг туршлагад үндэслэн хуулийн зорилт, зарчмыг уялдуулж, нэг бодлого, зохицуулалтыг бий болгож, жолооч бүр даатгуулах эсхүл тээврийн хэрэгслийн өмчлөгч нь даатгуулах зохицуулалтын хувилбаруудыг тодорхой болгож өөрчлөх нь зүйтэй байна. Үүнтэй холбоотойгоор даатгалын хураамж, үнэлгээг шинэчлэн тооцох, зам тээврийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хохирогчид олгох нөхөн төлбөр болон хувь хүний кредит онооны систем, зохицуулалтыг бий болгох боломжтой байна.

Хөгжингүй орнуудад албан журмын даатгалын даатгуулагч нь даатгалын тохиолдлыг харьцангуй их гаргасан тохиолдолд тухайн хүний бусад санхүүгийн үйлчилгээ авах боломжийг нь хязгаарласан зохицуулалтыг тусгасан байдаг.

Жолоочийн даатгалын сан нь жолоочийн даатгалд хамрагдаагүй, эсхүл гэрээний хугацаа дууссан, түүнчлэн зам тээврийн осол гаргасан жолооч зугтаасан болон даатгагч нь дампуурсан зэрэг тохиолдолд жолоочоос бусад этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилготой. Түүнчлэн Даатгалын тухай хуулийн 12' дүгээр зүйлд Албан журмын даатгалын холбоо нь жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий даатгалын мэдээллийн нэгдсэн сан, даатгагч, даатгуулагч, хохирогч, иргэнээс даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авч, даатгалын тохиолдлыг шуурхай, үнэн зөв тодорхойлох чиг үүрэг бүхий шуурхай алба, хохирогч этгээдийн нөхөн төлбөрийг олгох жолоочийн даатгалын сан гэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байдаг. Гэвч хуульд холбооны статус, эрх үүргийн талаар нарийвчлан зохицуулаагүйгээс хуульд тусгагдсан зарим чиг үүргийг биелүүлэхэд хүндрэл үүсдэг. Жолоочийн даатгалын сан нь буруутай этгээдээс хохирлыг буцаан нэхэмжлэх эрхийнхээ хүрээнд хуульд заасан үндэслэлээр даатгалын тохиолдлын хохирогчид нөхөн төлбөр олгохдоо даатгалын тохиолдолд холбогдогч талуудыг тодорхойлох баримт бичиг, бусдын амь нас эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус үед мэргэжлийн байгууллагын тодорхойлолт, акт, шийдвэр болон холбогдох бусад нэмэлт баримт бичгийг бүрдүүлэхийг шаарддаг нь хохирогчийн зүгээс хуульд заасан хугацаанд хохирлоо барагдуулж, нөхөн төлбөр авах боломжгүй нөхцөл байдлыг үүсгэдэг тул Холбооны чиг үүрэг, зорилгыг жолоочийн даатгалын сангийн зорилготой уялдуулсан зохицуулалтыг бий болгох шаардлага тавигдаж байна.

Зам тээврийн ослын хохирогч нь хуульд заасны дагуу Холбооны шуурхай албанд хандах шаардлагатай ба өнөөгийн байдлаар Холбооны шуурхай алба нь улсын хэмжээнд гарч буй зам тээврийн осол, даатгалын тохиолдлыг бүртгэх хангалттай хүчин чадалгүйн улмаас хохирогч даатгалын сангаас нөхөн төлбөр гаргуулах боломжгүйд хүрэх тохиолдлууд үүсч байна. Цаашилбал шуурхай алба нь хангалттай ажилладаггүйгээс үүсэх хариуцлагыг хүлээх субъект тодорхойгүй болох, даатгагчид өөрсдөө төлөөлөгчөө ажиллуулах эсвэл шуурхай албаны мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага этгээдийн ажиллах боломжийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлэхээр байна. Хуульд Албан журмын даатгалын холбооны шуурхай алба нь даатгагч, даатгуулагч, хохирогч иргэнээс жолоочийн даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авч, шуурхай, үнэн зөв тодорхойлох боломжийг даатгагч, даатгуулагч, хохирогчид бүрдүүлэх чиглэлээр туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг явуулна гэж заасан байдаг боловч практик дээр даатгалын компаниуд өөрсдийн шуурхай албаар дамжуулан даатгалын тохиолдлыг хянах, шалгах үйл ажиллагаа явуулсаар байна. Иймд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжаар бүрдсэн сангийн үйл ажиллагааг сайжруулж олон улсын жишигт хүргэх, даатгалын хураамжийн хэмжээг цаг үе, эрсдэлийн түвшинтэй тухай бүр уялдуулан шинэчилдэг, статистик мэдээллийг тухай бүр цуглуулж, боловсруулах асуудлуудыг хуульд тодорхой тусгах шаардлагатай байна.

Хууль нь зам тээврийн хөдөлгөөний улмаас хохирсон гуравдагч этгээдийн хохирлыг барагдуулах зорилготой тул хохирогчид нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг хялбаршуулах, даатгалын тохиолдлыг түргэн шуурхай баталгаажуулах, оролцоог тодорхой болгож, даатгалын тохиолдол гарсан үед цагдаагийн байгууллагын оролцоогүйгээр даатгалын нөхөн төлбөрийг шуурхай, чирэгдэлгүйгээр олгох талаарх зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Олон улсад даатгалын сангийн хөрөнгийн дийлэнх нь компанийн бонд, хувьцаа хэлбэрээр байршдаг. Жолоочийн даатгалын сангийн хөрөнгө 2020 оны жилийн эцсийн байдлаар 26.4 тэрбум төгрөгт хүрээд байгаа бөгөөд үүнээс 90% нь банкинд хадгаламж хэлбэрээр байршдаг. Иймд тус сангийн хөрөнгийг хөрөнгийн зах зээлд байршуулах замаар илүү олон хэлбэрт тархаан байршуулах боломжийг бий болгож, хөрөнгийн зах зээлийг дэмжих, улмаар даатгалын сангууд мэргэжлийн хөрөнгө оруулагч институц болон хөгжих боломжийг бүрдүүлэх юм.

Хуулийн дагуу жолоочийн даатгалын мэдээллийн сан нь Даатгалын тухай хуульд заасан албан журмын даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэл хэсэг бөгөөд тусдаа бүртгэлтэй, бие даасан мэдээллийн сан байхаар заасан. Жолоочийн даатгалын мэдээллийн сан нь даатгалын хураамж, итгэлцүүрийг тооцоход нэн чухал ач холбогдолтой тул түүнийг үнэн зөв мэдээллээр түргэн шуурхай, тогтмол баяжуулж ажиллах шаардлагатай байдаг. Гэвч даатгагчид цаг хугацаандаа мэдээллээ ирүүлэхгүй байх, ирүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ, хариуцлагын талаарх зохицуулалт тодорхойгүй байгаа нь мэдээллийн сангийн баяжуулалтад сөргөөр нөлөөлж байна. Мэдээллийн санд даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, хохирогчид олгосон нөхөн төлбөр, даатгагч, даатгуулагч, хохирогчийн болон жолоочийн даатгалтай холбоотой бусад мэдээллийг оруулна гэж хуульд заасныг цаг үеийн нөхцөл шаардлагатай уялдуулан жолоочийн даатгалтай

холбоотой бусад мэдээллээр баяжуулах, мэдээллүүдийг нэгтгэх, хадгалах шинэлэг арга замыг бий болгох шаардлагатай байна. Түүнчлэн хуульд жолоочийн даатгалын сангийн өмчлөгчийг тодорхой заагаагүйн улмаас жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлэгч субъект хоорондын маргаан үүсэх эрсдэлтэй байна.

Жолоочийн хариуцлагын даатгалын үнэлгээний доод хэмжээг 2011 онд хуулиар 5 сая болон 10 сая төгрөгөөр тогтоосон байдаг. Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ цаг үеэ даган өөрчлөгдсөөр байгаа хэдий ч хуульд даатгалын үнэлгээний хэмжээг төгрөгөөр илэрхийлсэн нь даатгалын хамгаалалт цаг хугацаа өнгөрөх тусам ач холбогдлоо алдах байдлыг үүсгэж болзошгүй байна. Иймд цаг үеийн нөхцөл шаардлагад тулгуурлан жолоочийн хариуцлагын даатгалын хураамж, үнэлгээний хэмжээг тогтоохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, инфляцийн түвшин, эрсдэлийн түвшинтэй уялдуулж тухай бүр тогтоодог зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь олон улсын сайн туршлагад нийцүүлэн авто тээврийн хэрэгслийн өмчлөгчийн бусдын өмнө хүлээх хариуцлагыг даатгуулах зарчмыг тусгаж, хуулийн нэр томъёоны тодорхойлолтын дутагдалтай талуудыг засварлахаас гадна даатгалын үнэлгээ, хураамж тооцох аргачлал, итгэлцүүрийг шинэчлэх, албан журмын даатгагчдын холбооны статус, бүтэц, зохион байгуулалт, эрх, үүргийн тодорхойгүй байдлыг өөрчлөх, мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах зэргээр албан журмын даатгалын үйл ажиллагаанд оролцогчдын эрх ашигт нийцсэн дараах шинэ зохицуулалтыг нэмж, өөрчлөн найруулж тусгах болно. Үүнд:

- 1.Хуулийн зарчмыг олон улсын сайн туршлагад үндэслэн тогтоох;
- 2.Хуулийн нэр томъёоллын тодорхойлолтыг сайжруулах;
- 3.Даатгалын үнэлгээ, хураамж тооцох аргачлал, итгэлцүүрийг хуулийн зарчмын өөрчлөлттэй холбоотойгоор шинэчилж найруулах;
- 4.Албан журмын даатгагчдын холбоог өөрчлөн зохион байгуулж, түүний статус, эрх, үүргийг илүү нарийвчлан тодорхойлох;
- 5.Даатгалын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх болон аливаа дэвшилтэд технологийг ашиглах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- 6.Жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах;
- 7.Даатгалын мэдээллийн сангийн зохицуулалтыг шинэчлэх;
- 8.Даатгагч, даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдох зохицуулалтыг сайжруулах;
- 9.Нөхөн төлбөр олгох зохицуулалтыг илүү шуурхай хялбаршуулах чиглэлээр сайжруулах.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар зам тээврийн хөдөлгөөнд оролцох үед учирч болзошгүй эрсдэлээс даатгуулах этгээдийг тээврийн хэрэгслийн өмчлөгч байх олон улсын жишигт нийцсэн зохицуулалт бий болж, үүнтэй холбоотойгоор хуулийн нэр томъёоны зарим тодорхойлолт, зохицуулалт дагаж өөрчлөгдөн, практикт тулгамдсан асуудлууд шийдвэрлэгдэж, даатгуулагчийн эрх ашиг хамгаалагдах юм. Сангийн хөрөнгийг илүү олон талт хөрөнгө оруулалтад байршуулах замаар үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, улмаар энэ нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд тодорхой дэмжлэг болох давуу талыг бий болно. Албан журмын даатгалын үйл ажиллагаанд аливаа дэвшилтэд технологи ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлснээр даатгалын тохиолдлыг баталгаажуулах, нөхөн төлбөр олгох зэрэг үйл явцыг хялбаршуулж, хүнд, суртал чирэгдэлтэй байдал багасч, улмаар даатгалын салбарт шинэлэг хөгжлийг бий болгоно. Даатгалын мэдээллийн сангийн холбогдох зохицуулалтыг сайжруулж, хураамж тооцох итгэлцүүрийг шинэчилснээр илүү бодит хүн бүрт харилцан ялгаатай даатгалын хураамжийн хэмжээг тогтоож, улмаар иргэний хариуцлага, кредит оноо буюу хувь хүний үнэлгээг бий болгох эхлэл болох юм.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын олон улсын гэрээ болоод Монгол Улсын Үндсэн хуульд бүрэн нийцэж байгаа бөгөөд бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй болно. Хуулийн төсөлтэй холбоотойгоор Зөрчлийн тухай, Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалах зорилгоор автотээврийн хэрэгслийн өмчлөгчийг заавал даатгалд хамруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомж

2.1. Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын зуучлалын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Автотээврийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“жолооч” гэж автотээврийн хэрэгсэл болон мотоциклийг жолоодож яваа хүнийг;

3.1.2.“автотээврийн хэрэгсэл” гэж Автотээврийн тухай хуулийн 3.1.1-д заасныг;

3.1.3.“даатгагч” гэж даатгуулагчтай жолоочийн даатгалын гэрээ байгуулж, уг гэрээнд заасан нөхцөл, хэмжээгээр хохирогчид нөхөн төлбөр олгох үүрэг хүлээсэн хуулийн этгээдийг;

3.1.4.“даатгуулагч” гэж даатгагчтай жолоочийн даатгалын гэрээ байгуулж, өөрийн өмчлөлийн автотээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оруулах үеийн бусад этгээдийн өмнө хүлээх хариуцлагаа даатгуулсан этгээдийг;

3.1.5.”нэхэмжлэгч” гэж энэ хуульд заасны дагуу нөхөн төлбөр авах эрхтэй этгээдийг;

3.1.6.“жолоочийн даатгалын нөхөн төлбөр” /цаашид “нөхөн төлбөр” гэх/ гэж жолоочийн даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгалын гэрээний дагуу даатгагчаас, энэ хуульд заасан бусад нөхцөлд Холбооноос хохирогчид олгох мөнгөн хөрөнгийг;

3.1.7.“жолоочийн даатгалын тохиолдол /цаашид “даатгалын тохиолдол” гэх/” гэж автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж, хариуцлага хүлээх тохиолдлыг;

3.1.8.“хохилогч” гэж даатгалын тохиолдлын улмаас эрүүл мэнд, эд хөрөнгөд нь хохирол учирсан этгээд, эсхүл даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас хохирсон тохиолдолд гэм хор учруулсны төлбөрийг шаардах эрх бүхий этгээдийг.

3.1.9.“хохилогчийн эрхийг хамгаалахтай холбоотой нэгдсэн зохион байгуулалтын бүтэц буюу холбоо” /цаашид “Холбоо” гэх / гэж жолоочийн даатгалд хамрагдаагүй, эсхүл гэрээний хугацаа дууссан түүнчлэн даатгалын тохиолдол гаргасан этгээд тодорхойгүй зэрэг тохиолдолд жолоочоос бусад этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нар хамтарч энэ хуульд заасны дагуу байгуулсан хуулийн этгээдийг;

4 дүгээр зүйл.Даатгалын зарчим

4.1. Жолоочийн даатгал нь дараах зарчимд үндэслэнэ:

4.1.1.автотээврийн хэрэгслийн өмчлөгч нь жолоочийн даатгалд заавал хамрагдах;

4.1.2.хохилогчид нөхөн төлбөрийг шуурхай олгох;

4.1.3.жолоочийн даатгалд даатгуулаагүй этгээдийн автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх;

4.1.4.автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах санхүүгийн эх үүсвэр бий болгох;

4.1.5.жолоочийн даатгалын үйл ажиллагааны зардлыг боломжит хамгийн бага түвшинд байлгах.

5 дугаар зүйл.Даатгуулах этгээд

5.1.Автотээврийн хэрэгслийн өмчлөгч бүр заавал даатгуулна.

5.2.Автотээврийн хэрэгслийн өмчлөгч жолоочийн даатгалд даатгуулаагүй тохиолдолд автотээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулах, техникийн хяналтын үзлэгт оруулах, улсын бүртгэлд бүртгүүлэхийг хориглоно.

6 дугаар зүйл.Даатгалд үл хамрагдах нөхцөл

6.1.Монгол Улс гишүүнээр нь элсэн орсон олон улсын заавал даатгалын холбооны гишүүн орны даатгалын эрх бүхий байгууллагад даатгуулсан этгээд энэ хуулиар тогтоосон даатгалд хамрагдахгүй байж болно.

6.2.Замын хөдөлгөөнд оролцдоггүй байлдааны тусгай зориулалттай болон мөрдөх алба, цагдаа, тагнуул, зэвсэгт хүчин, хилийн цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын автотээврийн хэрэгсэлд энэ хууль хамаарахгүй.

6.3.Нэхэмжлэгч нь даатгалын гэрээгээр тогтоосон хэмжээнээс давсан хохирлыг жолооч болон буруутай этгээдээс нэхэмжилсэн бол уг давсан хэсэгт энэ хууль үйлчлэхгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ

7 дугаар зүйл. Даатгалын гэрээ, түүний хугацаа

7.1.Автотээврийн хэрэгслийн өмчлөгч нь өөрийн автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулж болзошгүй хохирлыг нөхөн төлөх зорилгоор энэ хуульд заасан нөхцөлийн дагуу даатгагчтай даатгалын гэрээ байгуулна.

7.2.Энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан даатгалын гэрээг байгуулахын өмнө даатгуулагч мэдүүлгийг батлагдсан маягтын дагуу бөглөж даатгагчид бичгээр эсхүл цахимаар хүргүүлнэ.

7.3.Даатгалын гэрээг энэ хуулийн 7.4-т заасан загварын дагуу байгуулж, хуульд заасан хэлбэрээр баталгаажуулсан байна.

7.4.Даатгалын мэдүүлгийн болон гэрээний загварыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх / батална.

7.5.Даатгалын гэрээний хугацаа нь нэг жилээс илүүгүй байх бөгөөд энэ хуулийн 7.3-т заасан шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

7.6.Даатгалын гэрээний дагуу даатгагчийн хүлээх хариуцлага нь даатгуулагчаас даатгалын хураамж төлөгдсөн өдрийн дараах өдрөөс эхэлж, гэрээний хугацааны сүүлийн өдрийн 24.00 цагт дуусгавар болно.

7.7.Даатгагч нь даатгалын гэрээний хугацаанд бий болсон уг гэрээтэй холбоотой бүхий л мэдээллийг даатгуулагчид үнэ төлбөргүй гаргаж өгөх үүрэгтэй.

8 дугаар зүйл.Даатгалын баталгаа

8.1.Даатгалын гэрээ байгуулсан даруйд даатгагч нь гэрээ байгуулсныг гэрчлэх даатгалын баталгааг даатгуулагчид бичгээр болон цахимаар өгч болно.

8.2.Даатгуулагч нь даатгалын баталгааг эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд шалгуулна.

8.3.Даатгалын баталгааны загвар, хэрэглэх журмыг Хорооны дарга батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖ

9 дүгээр зүйл. Даатгалын үнэлгээ

9.1.Жолоочийн даатгалын үнэлгээний доод хэмжээ нь даатгалын тохиолдол бүрд дараах хэмжээтэй байна:

9.1.1.хохирогчийн амь нас, эрүүл мэндийн хувьд нэг хохирогчтой бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөг;

9.1.2.хохирогчийн амь нас, эрүүл мэндийн хувьд нэгээс дээш хохирогчтой бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөг;

9.1.3.хөрөнгийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөг;

10 дугаар зүйл. Даатгалын хураамж

10.1.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан даатгалын үнэлгээнд ногдох даатгалын суурь хураамжийн хэмжээг Хороо автотээврийн хэрэгслийн ангиллаас хамааруулан тогтооно.

10.2.Даатгалын хураамжийн хэмжээг тогтоохдоо даатгалын суурь хураамжийн хэмжээг итгэлцүүрээр /автотээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршил, өмнөх гэрээний хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээ, даатгалын гэрээний хугацаа гэх мэт/ нэмэгдүүлэх буюу хорогдуулан тооцох бөгөөд Даатгалын хураамж тооцох итгэлцүүр хэрэглэх журмыг Даатгалын тухай хуульд заасан Заавал даатгалын холбооноос ирүүлсэн саналыг харгалзан Хороо батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛ, ХЯНАЛТ

11 дүгээр зүйл. Зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

11.1.Хороо жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоно.

11.2.Хороо жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, олгохоос татгалзахтай холбоотой журмыг батална.

11.3.Хороо өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 21 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл. Санхүүгийн бүртгэл, тайлан

12.1.Даатгагч жолоочийн даатгалын үйл ажиллагааны санхүүгийн бүртгэлийг хийж, зардал үр дүнг тооцсон холбогдох тайланг Даатгалын тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасан санхүүгийн тайланд хавсарган Хороонд ирүүлнэ. Энэ хэсэгт заасан тайлангийн маягт, аргачлалыг Хороо батална.

13 дугаар зүйл. Даатгалын үйл ажиллагаанд тавих хяналт

13.1.Хороо нь жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчдын үйл ажиллагааны нэгдсэн уялдааг хангаж, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавина.

13.2.Даатгалын зуучлагчид олгох жолоочийн даатгалын шимтгэлийн дээд хязгаарыг Хороо тогтоож болно.

13.3.Даатгалын тохиолдол байнга гаргадаг гэсэн үндэслэлээр даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолоочийг даатгагчид хуваарилах журмыг Хороо батална.

13.4.Энэ хуулийн 5.1-5.2 дахь хэсгийн заалтын хэрэгжилтэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8.1 дэх хэсэгт заасан Цагдаагийн байгууллага болон Автотээврийн тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасан автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус хяналт тавина.

13.5.Даатгалын тухай хуулийн 20.2.1 дэх зүйлд заасан Заавал даатгалын холбоо нь энэ хуулийн 13.4 дэх хэсэгт заасан этгээдийг жолоочийн даатгалын мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.

13.6.Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа автотээврийн хэрэгслийг хилийн бүсэд жолоочийн даатгалд хамруулах журмыг Хороо батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ, НӨХӨН ТӨЛБӨР

14 дүгээр зүйл. Даатгалын тохиолдолд үл хамаарах хохирол

14.1. Дараах хохирол даатгалын тохиолдолд үл хамаарна:

14.1.1.сэтгэл санааны хохирол;

14.1.2.хүрээлэн байгаа орчныг бохирдуулснаас үүссэн хохирол;

14.1.3.даатгуулагчийн болон жолоочийн автотээврийн хэрэгсэл, ачаа, хөрөнгөнд учирсан хохирол;

14.1.4.автотээврийн хэрэгслийн тэмцээн, уралдаанд оролцсоны улмаас үүдсэн хохирол;

14.1.5.автотээврийн хэрэгсэл хулгайд алдагдсан, дээрэмдүүлсэн үеийн хохирол;

14.1.6.энэ хууль болон даатгалын гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан хохирол.

14.2.Энэ хуулийн 14.1-д заасан хохирлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

15 дугаар зүйл. Жолоочийн хүлээх үүрэг

15.1.Даатгалын тохиолдлын үед даатгуулагч дараах үүрэгтэй:

15.1.1.жолоочийн даатгалд даатгуулсан тухайгаа хохирогчид мэдэгдэх;

15.1.2.даатгалын тохиолдол гарсан талаар даатгагчид мэдэгдэх, даатгалын гэрээ, эсхүл баталгааг шалгуулах;

15.1.3.даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд даатгагч болон цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

15.1.4.даатгалын тохиолдол болон нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгагчийн болон эрх бүхий этгээдийн шаардсан хугацаанд гаргаж өгөх;

15.2.Даатгалын тохиолдол гаргасан даатгалгүй этгээд нь жолоочийн даатгалд даатгуулаагүй тухайгаа хохирогчид эсхүл цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

15.3.Энэ хуулийн 5.1-д заасан этгээд нь даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягыг даатгалын тохиолдол гарсан даруйд бөглөж, баталгаажуулна.

15.4.Даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлыг тухайн даатгалын тохиолдол гарсан даруйд жолооч хохирогчтой харилцан хүлээн зөвшөөрсөн бол даатгагчид энэ тухайгаа мэдэгдэж, даатгагчийн зөвшөөрлийн дагуу уг хохирлыг эргэн төлүүлэхээр жолооч барагдуулж болно.

15.5.Даатгуулагч энэ хуулийн 15.1, 15.4-т заасан үүргээ хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг даатгагч, Холбоо хариуцахгүй бөгөөд хохирлыг даатгуулагч өөрөө хариуцна.

15.6.Даатгалгүй этгээд энэ хуулийн 15.2-т заасан үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг даатгагч, Холбоо хариуцахгүй бөгөөд хохирлыг жолооч өөрөө хариуцна.

16 дугаар зүйл. Хохирогчийн эрх, үүрэг

16.1.Даатгалын тохиолдол гаргасан жолооч зугтаасан бол хохирогч энэ талаар даатгагч, цагдаагийн байгууллага, Холбооны аль боломжтойд нь мэдэгдэх эрхтэй.

16.2.Хохирогч нь амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөдөө учирсан хохирлыг нотлох бүх мэдээллийг даатгагч, Холбоонд гаргаж өгөх үүрэгтэй.

17 дугаар зүйл. Даатгагч, Холбооны эрх, үүрэг

17.1.Даатгагч, Холбоо нь нөхөн төлбөр буюу хохирлын хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгуулагч, хохирогчоос шаардах эрхтэй.

17.2.Даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авсан даруйд даатгагч, Холбоо нь даатгалын тохиолдол болсон газарт төлөөлөгчөө шуурхай илгээх, холбогдох даатгагчид эсхүл Холбоонд мэдэгдэх, даатгуулагчийг даатгалын тохиолдлыг шалгахтай холбоотой мэдээллийг шуурхай өгөх үүрэгтэй.

17.3.Энэ хуулийн 15.1-т заасан үүргийн талаар даатгагч нь даатгуулагчид даатгалын гэрээ байгуулах үедээ тайлбарлаж өгөх үүрэгтэй.

17.4.Даатгагч нь даатгалын тохиолдлын талаарх мэдээлэл авсан даруйд даатгалын тохиолдлын оролцогч нь даатгалтай бол түүний даатгагчид, даатгалгүй бол Холбоонд мэдэгдэнэ.

17.5.Даатгагч нь цагдаагийн байгууллагаас даатгалын тохиолдолтой холбоотой дүрс бичлэг, зам тээврийн ослын бүртгэлийг гаргуулж авах эрхтэй.

17.6. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэгч нь энэ хуулийн 24.2-т заасан мэдээллийг даатгалын тохиолдлыг шийдвэрлэсэн тухай бүр Жолоочийн даатгалын мэдээллийн санд хүргүүлэх үүрэгтэй.

18 дугаар зүйл. Даатгалын тохиолдлыг шалгах

18.1.Даатгагч, Холбоо нь хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, даатгуулагчаас даатгалын тохиолдлын талаар мэдэгдсэн даруйд даатгалын тохиолдлыг шалгах үүрэгтэй.

18.2.Даатгагч нь хуулиар зөвшөөрсөн даатгалын хохирол үнэлэх аливаа технологийг ашиглан даатгалын тохиолдлыг шалгах, хохирлын хэмжээг тогтоох зорилгоор тухайн автотээврийн хэрэгсэлд техникийн үзлэг хийж болно.

18.3.Даатгагч, Холбоо нь энэ хуулийн 18.1-д заасны дагуу даатгалын тохиолдлыг шалгаагүй бол даатгуулагч, жолооч, хохирогч нь даатгагчаас өгсөн чиглэлийн дагуу зураг, дуу ба дүрс бичлэгээр баримтжуулах эсхүл Даатгалын тухай хуульд заасан даатгалын хөндлөнгийн хохирол үнэлэгч этгээдэд хандах эрхтэй.

18.4.Даатгуулагч, жолооч, хохирогч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас даатгалын тохиолдлын талаар даатгагчид мэдэгдэх боломжгүй байх тохиолдолд зураг, дуу ба дүрс бичлэгээр даатгалын тохиолдлыг баримтжуулж, даатгагчид хүргүүлнэ.

18.5.Даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирлыг үнэлэхтэй холбогдон гарах зардлыг даатгагч, Холбоо хариуцна.

18.6. Даатгагч нь доор дурдсан нөхцөл бүрдсэн тохиолдолд даатгалын тохиолдлыг цагдаагийн байгууллагын оролцоогүйгээр бүртгэнэ:

18.6.1. даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учраагүй;

18.6.2. даатгалын тохиолдлын гэм буруугийн талаар талууд харилцан хүлээн зөвшөөрсөн.

18.6.3. даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягт, хэрэглэх журмыг Хороо баталж болно.

19 дүгээр зүйл. Хохирлын хэмжээг тодорхойлж, нөхөн төлбөр тооцох

19.1. Даатгагч, Холбоо нь хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээг Хуульд заасан даатгалын тохиолдлыг баталгаажуулах эрх бүхий этгээд, эсхүл хуулиар зөвшөөрсөн даатгалын хохирол үнэлэх аливаа технологийг ашиглан хохирлыг үнэлсэн дүгнэлт, тодорхойлолт, энэ хуулийн 19.2 дугаар зүйлд заасныг үндэслэн тооцно.

19.2. Хуульд өөрөөр заагаагүй бол даатгагч, Холбоо, даатгалын хохирол үнэлэгч болон хуульд заасан эрх бүхий этгээд нь хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээг дор дурдсаны дагуу тодорхойлно:

19.2.1. хохирогч нас барсан бол энэ хуулийн 9.1.1, 9.1.2-д заасан мөнгөн дүнгээр;

19.2.2. хохирогч 70 буюу түүнээс дээш хувиар хөдөлмөрийн чадвараа байнга алдсан нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон бол энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т заасан мөнгөн дүнгээр, ингэхдээ тухайн даатгалын тохиолдолтой холбоотой тухайн иргэний эрүүл мэндийн хохиролд даатгагч эсхүл Холбооноос өмнө төлсөн мөнгөн дүнг хасаж тооцно.

19.2.3. хохирогчийн эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээний талаар хохирогч, даатгуулагч, даатгагч талууд санал нэгдсэн бол энэ хуулийн 9.1 дэх хэсэгт заасан дүнд багтаан тэдгээрийн харилцан тохиролцсон хэмжээгээр;

19.2.4. хохирогчийн эрүүл мэндэд учирсан хохирлын хэмжээний талаар хохирогч, даатгуулагч, даатгагч талуудын санал зөрсөн бол энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т харгалзан заасан дүнд багтаан Иргэний хуулийн 505 дугаар зүйлд заасны дагуу;

19.2.5. хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээний талаар хохирогч, даатгуулагч, даатгагч талуудын санал зөрсөн бол энэ хуулийн 9.1.3-т харгалзан заасан дүнд багтаан Иргэний хуулийн 510 дугаар зүйлд заасны дагуу.

20 дугаар зүйл. Нөхөн төлбөр олгох

20.1. Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол даатгуулагчийн гэм буруутай нь тогтоогдсон эсэхээс үл хамааран даатгагч, Холбоо нь даатгалын тохиолдол болсноос хойш ажлын 10 өдрийн дотор нөхөн төлбөрийг хохирогчид олгоно.

20.2. Хохирогчийн эд хөрөнгөд хохирол учирсан бол даатгуулагчийн гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосноос хойш ажлын 10 өдрийн дотор нөхөн төлбөрийг хохирогчид олгоно.

20.3.Даатгагч, Холбоо нь хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлыг барагдуулахдаа даатгуулагч, жолооч, хохирогч нартай тохиролцсоны дагуу даатгалын үнэлгээнд багтаан эд хөрөнгийг засуулахаар тохиролцож болно.

20.4.Нөхөн төлбөрийн хэмжээг бүрэн тогтоох хүртэл хохирогчийн хүсэлтийн дагуу нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгож болно.

20.5.Нөхөн төлбөрийн хэмжээг бүрэн тогтоохоос өмнө хэд хэдэн хохирогчийн хүсэлтээр нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгохоор бол эхний удаад хохирогч бүрд ижил хэмжээгээр, хохирлын хэмжээ бүрэн тогтоогдсоны дараа хувь тэнцүүлэн олгоно.

20.6.Хэд хэдэн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан хэмжээнээс хэтэрсэн бол хохирогч бүрд олгох нөхөн төлбөрийг хувь тэнцүүлэн олгоно.

20.7.Жолоочийн даатгалын нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг Хороо баталж болно.

20.8.Даатгагч, Холбоо нь хохирогчид олгосон нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг улирал тутам Даатгалын тухай хуульд заасан Заавал даатгалын холбоонд хүргүүлэх ба тус холбоо мэдээллийг нэгтгэж, Хороо, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8.1 дэх хэсэгт заасан Цагдаагийн байгууллагад хүргүүлж ажиллана. Энэ заалтад дурдсан мэдээллийн зохицуулалтын журмыг Хороо батална.

21 дүгээр зүйл. Нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх үндэслэл

21.1.Даатгагч нь дараах тохиолдолд хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрхтэй:

21.1.1.хохирогчид хохирол учирсан нь даатгуулагчийн гэм буруутай холбогдолгүй болох нь хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдвол тухайн буруутай этгээдээс;

21.1.2.даатгалын тохиолдол гарсан талаар энэ хуулийн 5.1, 15.2-т заасан этгээдэд мэдэгдээгүй бол даатгуулагч, жолоочоос;

21.1.3.даатгуулагч нь даатгалын тохиолдол болсон газраас зугтаасан бол тухайн даатгуулагчаас;

21.1.4.даатгуулагч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ даатгалын тохиолдол гаргасан бол даатгуулагчаас;

21.1.5.хуульд заасан бусад тохиолдолд буруутай этгээдээс.

21.2.Холбоо нь дараах тохиолдолд хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрхтэй:

21.2.1.хохирогчид хохирол учирсан нь жолоочийн гэм буруутай холбогдолгүй болох нь хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдвол тухайн буруутай этгээдээс;

21.2.2.даатгалгүй этгээдийн гэм буруугаас шалтгаалан хохирогчид хохирол учирсан гэдэг нь хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдвол тухайн этгээдээс;

21.2.3.даатгалын тохиолдол гаргаад зугтаасан жолоочийн учруулсан хохирлын хувьд тухайн жолоочоос;

21.2.4.хуульд заасан бусад үндэслэл.

21.3.Энэ хуулийн 21.2-т заасан буруутай этгээд нас барсан эсвэл төлбөрийн чадваргүй болох нь шүүхээр тогтоогдсон бол Жолоочийн даатгалын сангийн нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх эрх дуусгавар болно.

21.4.Даатгагч нь дампуурсан бол түүний эрх залгамжлан авсан этгээдээс Даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан Заавал даатгалын баталгаат сан буцаан нэхэмжлэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ

22 дугаар зүйл. Хохирогчийн эрхийг хамгаалах

22.1.Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагч нар хохирогчийн эрхийг хамгаалахтай холбоотой нэгдсэн зохион байгуулалтын бүтэц буюу Холбоог Хорооны зөвшөөрлийг үндэслэн байгуулах үүрэгтэй.

22.2.Холбоо нь дараах тохиолдолд хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирлын нөхөн төлбөрийг олгоно:

22.2.1.даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан;

22.2.2.даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан;

22.2.3.даатгалын тохиолдлын буруутай этгээд тодорхойгүй;

22.2.4.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

22.3.Холбооны үйл ажиллагааны болон нөхөн төлбөрийн санхүүгийн эх үүсвэрийг Холбооны гишүүн даатгагч нар бүрдүүлнэ.

23 дугаар зүйл. Зохион байгуулалт

23.1.Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагч нь Холбооны заавал гишүүнчлэлтэй байна. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчингүй болсон бол даатгагч нь Холбооны гишүүнчлэлгүй болно.

23.2.Холбооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна. Гишүүн бүр саналын нэг эрхтэй ба олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэсэнд тооцно.

23.3.Холбооны хөрөнгийн эх үүсвэр нь гишүүдийн хураамж, хууль тогтоомжид заасан бусад орлого байх ба холбооны бүх гишүүдийн хурлаас томилсон хяналтын зөвлөлтэй байна.

23.4.Холбоо нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа улирал тутам Хороонд ирүүлэх ба нийтэд мэдээлнэ.

23.5.Холбооны үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд Хороо хяналт тавина.

23.6.Холбоо нь Хорооноос томилогдон хяналт хэрэгжүүлж буй этгээдэд шаардлагатай баримт, холбогдох тайлбарыг зохих журмын дагуу шуурхай, үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН САН

24 дүгээр зүйл. Жолоочийн даатгалын мэдээллийн сан

24.1. Жолоочийн даатгалын мэдээллийн сан /цаашид “мэдээллийн сан” гэх/ нь Даатгалын тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан Заавал даатгалын мэдээллийн сангийн бүрдэл хэсэг байна.

24.2. Мэдээллийн санд даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, даатгуулагчийн мэдүүлэг, хохирлын үнэлгээ, зам тээврийн осол, тээврийн хэрэгслийн засварын түүх, зөрчлийн тухай, хохирогчид олгосон нөхөн төлбөр, даатгагч, даатгуулагч, хохирогчийн болон жолоочийн даатгалтай холбоотой бусад мэдээллийг оруулна.

24.3. Мэдээллийн сан нь Даатгалын тухай хуульд заасан Заавал даатгалын холбооноос санхүүжих бөгөөд мэдээллийн сан дахь аливаа мэдээлэл нь төрийн өмч байна.

24.4. Жолоочийн даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцож буй этгээдүүд болох даатгагч, Холбоо, даатгуулагч өөртэй нь холбоотой мэдээллийг, түүнчлэн жолоочийн даатгалтай холбоотой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж байгаа төрийн байгууллага, албан тушаалтан мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах эрхтэй.

24.5. Мэдээллийн сангийн мэдээллийг ашиглуулах журам, үйлчилгээний хөлсний хэмжээг Даатгалын тухай хуульд заасан Заавал даатгалын холбооны саналыг харгалзан Хороо батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД

25 дугаар зүйл. Гомдол, маргаан шийдвэрлэх

25.1. Жолоочийн даатгалтай холбогдон гарсан гомдол, маргааныг Даатгалын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

26 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

26.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

26.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

27 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

27.1. Энэ хуулийг ... оны .. дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.15 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “төгрөгөөр” гэсний дараа “хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл.Автотээврийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 17^{1.5} дахь хэсгийг нэмсүгэй.

“17^{1.5}.Энэ хуулийн 17^{1.1} дүгээр зүйлд заасан этгээд нь тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлэхээс өмнө уг тээврийн хэрэгслийг даатгалд хамруулсан байна.”

2 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “дараа” гэсний өмнө “даатгалд хамруулсны” гэж нэмсүгэй.”

3 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн дахь хэсгийн “хангуулсны” гэснийг “хангуулж,” гэж өөрчилсүгэй.”

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ